




**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

|   |  |                          |                          |
|---|--|--------------------------|--------------------------|
| Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/   |  |                          |                          |
| Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй. |  |                          |                          |
|   |  |                          |                          |
| Тайлагнах хугацаа<br>/Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/  | 2024 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр  |                          |                          |
| Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар  | “Монголын цахилгаан холбоо” ХК<br>УБГД:000000376<br>Үнэт цаасны код:209<br>15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө 1,<br>Утас:70102248        |                          |                          |
| Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр  | “Монголын хөрөнгийн бирж” ХК   |                          |                          |
| Бизнесийн үйл ажиллагааны салбар  | Харилцаа холбоо, мэдээлэл технологийн салбар   |                          |                          |
| Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг   | 25,870,276   |                          |                          |
| Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр   | Бэлтгэсэн:<br>Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br>Т.Бямбасүрэн, БТАлбаны ерөнхий менежер<br>Хянасан:<br>Ж.Баасандорж, Инновац бизнес хөгжлийн газрын захирал |                          |                          |
|   |  |                          |                          |
| 1.  | Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/  |                          |                          |
| Санхүүгийн байдлын үзүүлэлт   | <b>Үзүүлэлт</b>  | <b>Эхний үлдэгдэл</b>    | <b>Эцсийн үлдэгдэл</b>   |
|   | <b>ХӨРӨНГӨ</b>   |                          |                          |
|   | Эргэлтийн хөрөнгө  | 13,809,299,922.52        | 19,006,681,720.87        |
|   | Эргэлтийн бус хөрөнгө  | 54,206,606,900.44        | 45,505,323,332.70        |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>  | <b>68,015,906,822.96</b> | <b>64,512,005,053.57</b> |
|   | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>   |                          |                          |
|   | Богино хугацаат өр төлбөр  | 10,564,343,151.21        | 12,612,661,022.59        |
|   | Урт хугацаат өр төлбөр   | 7,083,823,446.52         | 1,503,973,693.32         |
|   | Эзэмшигчдийн өмч   | 50,367,740,225.23        | 50,395,370,337.66        |
|   | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>   | <b>68,015,906,822.96</b> | <b>64,512,005,053.57</b> |

|  | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|--|---|--------------------------|--------------------------|
| Орлогын тайлан   | <b>Борлуулалтын орлого /цэвэр/</b>  | <b>18,938,223,103.01</b> | <b>14,920,438,681.43</b> |
|  | Борлуулалтын өртөг  | (14,704,824,592.67)      | (12,843,336,866.06)      |
|  | <b>Нийт ашиг (алдагдал)</b>   | <b>4,233,398,510.34</b>  | <b>2,077,101,815.37</b>  |
|  | Түрээсийн орлого  | 649,693,435.66           | 293,268,970.19           |
|  | Хүүний орлого   | 164,718,433.72           | 64,246,948.52            |
|  | Бусад орлого  | 514,144,459.22           | 52,710,501.85            |
|  | Борлуулалт, маркетингийн зардал   | (1,448,188,458.72)       | (909,525,027.21)         |
|  | Ерөнхий ба удирдлагын зардал  | (2,979,884,438.96)       | (554,320,558.79)         |
|  | Санхүүгийн зардал   | (225,432,665.67)         | (460,821,462.68)         |
|  | Бусад зардал  | (869,065,134.37)         | (484,460,740.64)         |
|  | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)  | (1,994,038.18)           | 520,459.14               |
|  | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)  | 78,681,818.18            | -                        |
|  | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>  | <b>116,071,921.22</b>    | <b>78,720,905.75</b>     |
|  | Орлогын татварын зардал   | (87,214,478.89)          | (38,430,172.76)          |
| <b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>   | <b>28,857,442.33</b>  | <b>40,290,732.99</b>     |                          |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан  | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|  | Өмч   | 2,587,027,589.00         | 2,587,027,589.00         |
|  | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл   | 14,088,188,462.23        | 14,088,188,462.23        |
|  | Эздийн өмчийн бусад хэсэг   | 8,247,270,172.39         | 8,247,270,172.39         |
|  | Хуримтлагдсан ашиг  | 25,445,254,001.61        | 25,472,884,114.04        |
|  | <b>Нийт дүн</b>   | <b>50,367,740,225.23</b> | <b>50,395,370,337.66</b> |
| Мөнгөн гүйлгээний тайлан   | Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл           | Эцсийн үлдэгдэл          |
|  | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ   | 1,410,625,413.20         | 701,039,511.82           |
|  | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ   | (966,928,837.96)         | (479,913,825.62)         |
|  | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ   | 77,743.00                | (4,799,563.80)           |
|  | <b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>   | <b>443,774,318.24</b>    | <b>216,326,122.40</b>    |
|  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 308,008,601.51           | 751,782,919.75           |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>   | <b>751,782,919.75</b>   | <b>968,109,042.15</b>    |                          |
| 2.   | Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт |                          |                          |
| <b>“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК-ИЙН<br/>ТУЗ-ИЙН АУДИТЫН ХОРОО</b>  |   |                          |                          |
| 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр   |   | № 01                     | Улаанбаатар хот          |
| <b>ТУЗ-ИЙН ХУРАЛД ОРУУЛАХ САНАЛ</b>  |   |                          |                          |
| Тайлбар:<br>МЦХ ХК-ийн удирдлагаас ТУЗ-д хэлэлцүүлэхээр 2024 оны эхний хагас жилийн Бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгод түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал мөн Үндэсний аудитын газартай байгуулсан гэрээгээр тус компанийн 2023 оны санхүүгийн тайланд аудит хийсэн |   |                          |                          |

|   |  |  |                |                |
|---|--|--|----------------|----------------|
| <p>“Ихмонгол хөлөг-Аудит” ХХК-иас тавьсан төлбөрийн акт, хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн байна.</p> <p>Аудитын хорооны гишүүд ирүүлсэн төлөвлөгөөний гүйцэтгэл, өөрчлөлт оруулах санал, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлттэй танилцаад тодорхой асуудлыг тус компанийн холбогдох албан тушаалтнуудаас тодруулсан.</p> <p>Санал:</p> <p>Компанийн удирдлагаас ирүүлсэн материал, холбогдох албан тушаалтнуудын өгсөн тайлбар, хариултыг хэлэлцээд Аудитын хорооноос дараах саналыг ТУЗ-ийн хуралд хэлэлцүүлэхээр оруулж байна. Үүнд:</p> <p><b>1. 2024 оны бизнес төлөвлөгөөний талаар</b></p> <p>“Ти Ди Би Секьюритис” компани нь МЦХ компанийн хувьцааг олон нийтэд санал болгох ажлыг гадаад, дотоодын сонирхогчдын дунд зохион байгуулж, сурталчилсан боловч тус компанийн МЦХ компанид 2024 оны 8 дугаар сарын 7-нд ирүүлсэн 3/255 дугаар албан бичигт дурдсан шалтгаануудын улмаас стратегийн болон боломжит хөрөнгө оруулагчид татгалзсан хариу өгчээ. Үүнээс үзэхэд тус компанийн нэмэлт хувьцаа гүйцэд борлуулагдах баталгаа байхгүй байна. Иймд 2024 оны Бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тодотгол хийж, шинэчлэн батлахыг дэмжиж байна.</p> <p><b>2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн талаар</b></p> <p>Тус компанийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн талаар Үндэсний аудитын газар болон “Ихмонгол хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн тайлангаас харахад 30-100 хувийн гүйцэтгэлтэй буюу дунджаар 82 хувийн биелэлттэй байна.</p> <p>2024 оны санхүүгийн тайланд аудит хийх байгууллага 2023 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэг бүрчлэн шалгаж, биелэлтийг нь дахин гаргах үүрэгтэй.</p> <p>Аудитын хорооноос дээр дурдсан газруудад хүргүүлсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн тайланг дэмжиж байгаа бөгөөд энэ онд багтаан дутуу биелэлттэй байгаа албан шаардлага, зөвлөмжийг гүйцэд биелүүлж, өмнөх алдаа, зөрчлийг дахин давтахгүй, зөрчилгүй ажиллахыг компанийн удирдлагад үүрэг болгох саналтай байна.</p> <p style="text-align: center;"><b>АУДИТЫН ХОРОО</b></p> |  |  |                |                |
| 3.  | Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт |  |                |                |
| 3.1   | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/  | <b>Үзүүлэлт</b>                        | <b>2023.Q4</b> | <b>2024.Q2</b> |
|   |  | Нийт ашгийн хувь                       | 22.4%          | 13.9%          |
|   |  | Цэвэр ашгийн хувь                      | 0.2%           | 0.3%           |
|   |  | Нийт хөрөнгийн өгөөж ROA               | 0.00042        | 0.00062        |
|   |  | Өөрийн хөрөнгийн өгөөж ROE             | 0.00057        | 0.00080        |
| 3.2   | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт  | <b>Үзүүлэлт</b>                        | <b>2023.Q4</b> | <b>2024.Q2</b> |
|   |  | Эргэлтийн харьцаа                      | 1.31           | 1.51           |
|   |  | Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа        | 0.98           | 1.17           |
|   |  | Өр төлбөр болон өөрийн хөрөнгө харьцаа | 0.35           | 0.28           |

|     |   |  |
|-----|---|--|
|     | <p>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл 3.3 хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</p>   | <p><b>Нэг. Бизнес өргөжүүлэх</b></p> <p>1. ФТТН төслийн хүрээнд Завхан аймгийн Тэс сум, Сэлэнгэ аймгийн Түшиг сум, Булган аймгийн Хангал сумдад гуравласан үйлчилгээ нэвтрүүллээ.</p>  <p>2. БШУЯамтай хамтран боловсрол, сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байранд утасгүй дотоод сүлжээний орчин бүрдүүлэх төсөл хэрэгжүүлж нийслэл, орон нутгийн төрийн өмчит 228 сургуулийн сургалт, дотуур байр болон МСҮТ-ийн байранд дотоод сүлжээг байгуулах ажил 100 хувь гүйцэтгэлээ.</p> <p><b>Хоёр. Техник технологийн шинэчлэл</b></p> <p>1. Системийн ашиглалт үйлчилгээний хяналт мониторингийн системийг боловсронгуй болсноор IP сүлжээний тоног төхөөрөмж гэмтэл саатлыг хугацаа алдалгүй тодорхойлох, гэмтэл саатлын үед техник зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах, үйлчилгээний гомдол бууруулах боломжтой боллоо.</p> <p>2. Олон сувгийн телевизийн үйлчилгээний стандартын дагуу 64 сувгийн хяналт мониторингийн систем бий болголоо. Уг хяналтын системээр телевизийн ашиглалт үйлчилгээг бүрэн хянах, телевизээс ирж буй дуу, дүрсний хяналтыг бүрэн хийх, орон нутгийн студийн тоног төхөөрөмжүүдэд хэмжилт тохиргоо хийх боломж бүрдлээ.</p> |
| 3.4 | <p>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</p>   | <p>Тайлант хугацаанд санхүүгийн тайлангийн гадуур бүртгэсэн ажил гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт байхгүй.</p>  |
| 4.  | <p>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</p> |  |
|     | <p>Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.</p>   |  |
| 5.  | <p>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</p>  |  |
|     | <p>Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.</p>  |  |
| 5.  | <p>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</p>   |  |




## ЗАСАГЛАЛЫН БҮТЭЦ



### Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Монголын цахилгаан холбоо ХК-ийн нийт хувьцааны 94.7 хувь буюу 24,499,287 ширхэг хувьцааг Монгол Улсын Засгийн газар, 5.3 хувь буюу 1,370,989 ширхэг хувьцааг Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд тус тус эзэмшиж байна.



### Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хувьцаа эзэмшигчдийн хурлын эзгүйд компанийн бизнесийн үйл ажиллагааг удирдан явуулахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байдаг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны нэг (1/3) хараат бус гишүүн бөгөөд ердийн 6 гишүүн нь төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлдэг.

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгосон. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

#### ТУЗ-ийн дарга



**Ц.БАЯР-ЭРДЭНЭ**  
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга

#### Ердийн гишүүд



**Б.ТӨРБАТ**  
ЗГ-ийн хэрэг эрхлэх газар, Хууль, эрхзүйн газар, шинжээч



**Б.Билэгдэмбэрэл**  
ЦХХХЯ-ны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Мэдээллийн технологийн зөвлөх инженер



**А.МОЛОР**  
Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газар,  
Төрийн өмчийн удирдлага,  
зохицуулалтын хэлтэс,  
мэргэжилтэн



**Д.НАРАНГЭРЭЛ**  
Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын  
Төрийн өмчийн бүртгэл,  
ашиглалтын хэлтсийн  
дарга,  
Мэргэшсэн нягтлан бодогч



**С.ГАНЗОРИГ**  
ЦХХХЯ-ны Салбарын  
хяналтын газрын дарга

**ХАРААТ БУС ГИШҮҮД**



**Ц.НОРОВЖАМЦ**  
Интер аудит ХХК-ийн гэрээт  
аудитор



**Х.БАЯНБАЙ**  
Акпар-Аудит компанийн  
Ерөнхий захирал



**С.ЦОЛМОН**  
Мандах их сургуулийн  
Ахисан түвшний  
сургуулийн захирал

6. Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл

2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тайлан мэдээлэл –

<https://telecommongolia.mn/shareholders>

Хурлын нэр: Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Огноо: 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 11:00-14:20

Хуралдсан газар: Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн хурлын заал

Хурлын дарга: Жанчивдоржийн Баасандорж, МЦХ ХК-ийн Инновац, бизнес хөгжлийн газрын захирал

Тооллогын комисс: Дарга: С.Цог, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн,

Гишүүд: Т.Бямбасүрэн, Бодлого төлөвлөлтийн албаны ерөнхий менежер Э.Булганчимэг, ИБХГ-ын техник төлөвлөлтийн мэргэжилтэн

Хурал зохион байгуулах комисс: Дарга: Ч.Цогтгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын захирал, Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер

Ирц: Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,501,004 ширхэг саналын эрх бүхий 18 хувьцаа эзэмшигч оролцож ирц 94.71%

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай;
4. 2023 оны ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол, үндэслэлийг танилцуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай;

Гаргасан шийдвэрүүд:


1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах, тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч батлав.
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын тайланг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
  - Нийт хөрөнгийг 68,015,906,822.96 (Жаран найман тэрбум арван таван Хуудас 2/2 сая есөн зуун зургаан мянга найман зуун хорин хоёр төгрөг ерэн зургаан мөнгө), үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 54,206,606,900.44 (Тавин дөрвөн тэрбум хоёр зуун зургаан сая зургаан зуун зургаан мянга есөн зуун төгрөг дөчин дөрвөн мөнгө) -өөр;
  - Өр төлбөрийн нийт дүнг 17,648,166,597.73 (Арван долоон тэрбум зургаан зуун дөчин найман сая нэг зуун жаран зургаан мянга таван зуун ерэн долоон төгрөг далан гурван мөнгө) -өөр;
  - Эзэмшигчийн өмчийг 50,367,740,225.23 (Тавин тэрбум гурван зуун жаран долоон сая долоон зуун дөчин мянга хоёр зуун хорин таван төгрөг хорин гурван мөнгө) -өөр
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын хуулийн этгээдийн хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрөв.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.
  - Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан С.Цолмон, Х.Баянбай, Ц.Норовжамц нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Д.Нарангэрэл, Б.Билэгдэмбэрэл, С.Ганзориг, А.Молор, Б.Төрбат, Ц.Баяр-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сонгов.
  - Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүний үүрэгт ажлаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тус тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
  - Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, 2024 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.

- Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсвийг хавсралтаар батлав.



Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

|  |  |
|--|--|
| <p>Овог, нэр: <i>Баатаржав Чинбат</i></p> <p>Албан тушаал: "МНХ" ХК-ийн <del>зөвлөх</del> захирал</p> <p>Гарын үсэг: ..... </p> |  |
|--|--|



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

|  |   |
|--|---|
| <p>Овог, нэр: <i>Хуягийн Цэцэгмаа</i></p> <p>Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга</p> <p>Гарын үсэг: ..... </p> | <p>Овог, нэр: <i>Төмөрбаатарын Бямбасүрэн</i></p> <p>Албан тушаал: Бодлого төлөвлөлтийн албаны ерөнхий менежер</p> <p>Гарын үсэг: ..... </p> |
|--|---|